

БУГАТ ХОТЫН НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ТУХАЙ

*Н.Төмөр**

Бугат хот нь БНХАУ-ын ӨМӨЗО-ны төв хэсэгт, Хатан голын эрэг дээр Хөх хотоос баруун тийш 150 км-ийн зайд оршдог. Бугат хотын нийт талбайн хэмжээ 28 мян.хавтгай дөр.км, нийт хүн амын тоо 2,06 сая, үүнээс 53 мянга нь монголчууд юм.¹

Бугат хот нь Хятад улсын аж үйлдвэрийн томоохон хотуудын нэг. 2004 оны эхний хагас жилийн байдлаар тус хотын ДНБ 27,49 тэрбум юаньд хүрч, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний хэмжээ 2003 оны мөн үеийнхээс 1,826 тэрбум юань буюу 39,1 %-иар өсчээ.²

ӨМӨЗО-ны аж үйлдвэрийн гол салбарын нэг болох Бугатын хар төмөрлөгийн цогцолбор 1959 онд байгуулагдаж, БНХАУ-ын хар төмөрлөгийн томоохон цогцолборын нэг болжээ.³ Бугатын хар төмөрлөгийн цогцолборыг байгуулах болсон нь Бугат хотын нэг дүүрэг болох Баян-Овоогийн холимог төмөрлөгийн уурхайтай салшгүй холбоотой. Энэхүү холимог төмөрлөгийн уурхай нь төмөр, газрын ховор төмөрлөг болон ниобий төмөрлөгөөр нэлээд баялаг юм. Баян-Овоогийн төмрийн хүдрийн нийт нөөц нь 1 тэрбум гаруй тн бөгөөд газрын ховор төмөрлөгийн нөөцөөр дэлхийд нэгдүгээрт, ниобийн нөөцөөр Бразилийн дараа дэлхийд хоёрдугаарт орно. Үүнээс гадна Баян-Овоогийн уурхай фосфор, магни, кали, алт зэрэг 142 нэр төрлийн төмөрлөгийг зохих хэмжээгээр агуулсан байдаг.⁴

Бугатын хар төмөрлөгийн цогцолбор эдүгээ 38 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргадаг, үндсэн хөрөнгийн хэмжээ 24,6 тэрбум юаньд хүрч, жилд 8 сая тн төрөл бүрийн ган болд, 3 сая ган болдын бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай.⁵

Бугат хотод газрын ховор төмөрлөгийг боловсруулах чиглэлээр нийт 30 үйлдвэр аж ахуйн газар ажилладаг. Орчин үеийн нарийн техник технологи бүхий үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд газрын ховор төмөрлөг нэн чухал үүрэг гүйцэтгэдэг билээ. Жишээ нь; радио электроник, атомын техник, машин механизм, хими болон хар, өнгөт төмөрлөгийн үйлдвэрт газрын ховор төмөрлөгийг хэрэглэхээс гадна шилний үйлдвэрт мөн түүнийг хэрэглэснээр шилний тунгалаг шинж чанарыг нэмэгдүүлдэг. Газрын ховор төмөрлөгийг будаг, лакийн үйлдвэрт хэрэглэдэг ба зарим тэсрэмтгий бодис, тусгай чанарын ган болд, хайлш гаргахад мөн ашиглана.⁶ Одоогийн байдлаар газрын ховор төмөрлөгийн дэлхийн нөөц нь 45 сая орчим тн байгаагаас Бугатын Баян-Овоогийн нөөц нь 33 сая орчим тн байгаа юм.

*Н.Төмөр - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

БНХАУ-ын газрын ховор төмөрлөгийн хүдрийн дэлхийн олборлолтын нийт хэмжээний гуравны хоёр хувийг эзэлдэг бөгөөд 1999 оны байдлаар Хятад Улс 50 мян.тн газрын ховор төмөрлөгийн хүдрийг экспортонд гаргасан нь дэлхийн зах зээлийн нийт хэрэгцээний 88%-ийг хангажээ.⁷

Бугатын газрын ховор төмөрлөгийн өндөр шинэ техник технологитой үйлдвэрийн нээлттэй бүс БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн шийдвэрээр 1991 онд байгуулагджээ. Тус нээлттэй бүсэд 253 үйлдвэр аж ахуйн газар ажиллаж байгаагаас АНУ, Франц, Япон, Англи зэрэг улс орны хөрөнгө оруулалттай 30 үйлдвэр ажилладаг ба 1998 оны байдлаар тус бүсийн аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний хэмжээ 2,23 тэрбум юаньд хүрч, ашиг нь 240 сая юань болжээ.⁸

Бугат хотод эдүгээ хар төмөрлөг, өнгөт төмөрлөг, газрын ховор төмөрлөг, машин механизм, хүнд даацтай ачааны машин, бага оворын трактор, электрон, хими, хөнгөн хүнсний олон үйлдвэр ажиллаж 3000 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Бугатын аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний хэмжээ 1996 оны байдлаар 20,493 тэрбум юаньд хүрсэн нь ӨМӨЗО-ны аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 25 гаруй хувийг эзэлжээ.⁹

Бугатын үржил шимтэй газар нутагт хөдөө аж ахуйг хөгжүүлэх бүрэн бололцоотой. Энэ нутагт улаан буудай, гурвалжин будаа, эрдэнэ шиш, овъёос, наранцэцэг, буурцаг, шар будаа, чихрийн манжин болон олон төрлийн жимс ногоо ургахаас гадна, орон нутгийн онцлог бүхий эмийн ургамал бас ургадаг. Мал аж ахуйн хувьд 5 хошуу малтай. 1996 оны байдлаар Бугат хотод 5,87 мян.тн үр тариа, 55 мян.тн тосны ургамал, 417 мян.тн идэшний ногоо, 290 мян.тн чихрийн ургамал, 13 мян.тн жимс, 37 мян.тн мах /нийт 3180 мян.толгой малтай байсан/, 23 мян.тн сүү, 3200 тн хонины ноос, 146 тн ямааны ноолуур үйлдвэрлэн хүн амын хэрэгцээг хангасан.¹⁰

Хот байгуулалтын талаар Бугат хот нэлээд амжилт олж, тухайлбал 1128 км урт ус дамжуулах хоолойтой цэвэр усны хангамжийн сүлжээг байгуулан ашиглалтанд оруулснаар тус хотын бүх өрх айлыг үндсэндээ цоргоны цэвэр усаар хангах болсон. Хотыг моджуулах, зүлэгжүүлэх, цэцэгжүүлэх зорилгоор жил бүр сая гаруй мод суулган, 100 мян. гаруй хавтгай дөр.метр газар талбайг зүлэгжүүлж цэцэг тарьдаг. Орон сууцны барилга бичил хороололын хэлбэрээр сүндэрлэх болсон.¹¹

Бугат хотын нийгэм-эдийн засгийн хөгжилд зам харилцаа их үүрэг гүйцэтгэдэг билээ. Бээжин хотыг НХҮӨЗО /Нинся Хотон Үндэстний Өөртөө Засах Орон/-ы төв Иньчуань хоттой /энэ зам Бугат хотоор дамжин өнгөрнө/, Бугат хотыг ГЧҮӨЗО /Гуанси Чжуан

Үндэстний Өөртөө Засах Орон/-ы төв Наньнин хоттой холбосон зам, Бугат-Хөх хотын өндөр хурдны зам зэрэг авто зам болон Бугат-Бээжин, Бугат-Ланьчжоу зэрэг төмөр зам Бугат хотыг Ланьчжоу /Ганьсу мужийн төв/, Тайюань /Шаньси мужийн төв/, Си-ань /Шэньси мужийн төв/ зэрэг хотуудтай хуурай замаар холбожээ. Бугат хот нь 12 агаарын шугамаар Бээжин, Шанхай, Чэньду, /Сичуань мужийн төв/, Чунцин, Гуандун /Гуандун мужийн төв/, Гуйян /Гуйчжоу мужийн төв/, Ханчжоу /Чжэцян мужийн төв/, Гонконг, Куньмин /Юньнань мужийн төв/, Наньжин /Цзянсу мужийн төв/, Шантоу, Урумчи /СУӨЗО-ны төв/, Сямэнь зэрэг муж, өөртөө засах орны төв болон томоохон хотуудтай харилцаатай байхаас гадна Бугат хот Франкфурт, Хельсинк, Нью-Йорк, Парис, Сан-Франциско, Сингапур, Стокгольм зэрэг хотуудын хооронд шууд нислэг хийдэг.¹²

Бугат хотынхон боловсрол, шинжлэх ухааныг хөгжүүлэх үйлсэд нэлээд ололт амжилт гарган “бага боловсролоос дээд боловсролд”, “ерөнхий боловсролоос тусгай мэргэжилийн боловсролд” гэсэн мэдлэг боловсрол олгох сүлжээг байгуулан, шинжлэх ухааны олон салбарыг хамарсан эрдэм шинжилгээний байгууллагатай болов. Бугат хотод Бугатын хар төмөрлөгийн дээд сургууль, Бугатын ажилчин албан хаагчдын дээд сургууль, Бугатын анагаах ухааны дээд сургууль зэрэг 3 дээд сургуульд нийт 5372 оюутан, Бугатын санхүү эдийн засгийн техникум, Бугатын хөдөө аж ахуйн техникум, Бугатын аж үйлдвэрийн техникум, Бугатын төмөр замын барилга байгууламжийн техникум, Бугатын машин механизмын аж үйлдвэрийн техникум зэрэг 13 техникумд нийт 8557 оюутан, 16 ТМС-д нийт 8500 сурагч, ерөнхий боловсролын сургуульд нийт 174,6 мянган хүүхэд тус тус суралцдаг. Бугат хотод байгаль орчныг хамгаалах, хөдөө аж ахуй, ой мод, мэдээлэл зүй зэрэг салбарыг хамарсан 65 эрдэм шинжилгээний байгууллагад байгалийн шинжлэх ухааны чиглэлээр 49 мян. хүн, нийгмийн шинжлэх ухааны чиглэлээр 15 мян. хүн ажилладаг.¹³ Бугатын эрдэмтэд тус хотын нийгэм эдийн засгийг хөгжүүлэхэд зохих хувь нэмрээ оруулсаар ирлээ.

Бугатын эдийн засгийг цаашид хөгжүүлэхэд хүнд аж үйлдвэрийг хөгжүүлэхийн зэрэгцээ байгалийн нөөц баялгийг зөв зохистой ашиглан, байгаль орчныг хамгаалж, экологийн тэнцвэрт байдлыг хадгалахын тулд хөнгөн аж үйлдвэр, ахуйн үйлчилгээ, аялал жуулчлалыг мөн эрчимтэй хөгжүүлэх шаардлагатай хэмээн хятадын эрдэмтэд үздэг.¹⁴

Бугат хотын эдийн засаг цаашид улам бүр хөгжих нь дамжиггүй бөгөөд энэ нь ӨМӨЗО-ы эдийн засгийн хөгжилд эерэг нөлөө үзүүлэх төдийгүй, Хятад улсын төрөөс явуулж буй Баруун бүс нутгийг хөгжүүлэх стратегийн бодлогыг амжилттай хэрэгжүүлэхэд нэн чухал ач холбогдолтой юм.

ТАЙЛБАР, ЗҮҮЛТ:

1. У Кан-пин. Баруун бүс нутгийн эдийн засгийн өсөлтийн арга зам /Сибу цзинцзи цзэньчжан дэ фанши юй туцзин/, Бээжин, 2004, 286 дахь тал.
2. Өвөр Монголын Улс ардын аж ахуйн 2004 оны зургаадугаар сарын статистикийн мэдээ.
3. “Хятад Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орон /1947-1997 г,Бээжин, 1997, 63 дахь тал., “Автономный район Внутренняя Монголия Китайской Народной Республики”, Москва, 1980, стр.82
4. “Хятад Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орон /1947-1997/”,Бээжин, 1997, 63 дахь тал., “Өвөр Монголын их толь бичиг” /Нэймэнгу да цыдянь/, Хөх хот, 1991, 246дахь тал.
5. “Хятад Улсын Баруун бүс нутаг-Өвөр Монгол” /Чжунго сибу-Нэймэнгу/, Бээжин, 2001, 65 дахь тал.
6. А.И.Бусев, И.П.Ефимов. Химийн тодорхойлолт, ойлголт, нэр томьёо, УБ, 1987, 163 дахь тал. Газрын ховор төмөрлөг гэдэг нэр анх 18-р зууны эцэс, 19-р зууны эхээр бий болсон. Газрын ховор төмөрлөгт: лантан, церий, празеодимий, неодим, прометий, самарий, европий, гадолоний, тербий, диспрозий, гольмий, эрбий, тулий, иттербий, лютеций зэрэг элементүүдийг агуулсан байдаг.
7. “Хятад Улсын Баруун бүс нутаг-Өвөр Монгол” /Чжунго сибу-Нэймэнгу/, Бээжин, 2001, 64 дэх тал.
8. “China Today 99”, China Statistics Press, Beijing, 1999, p.465
9. <http://www.bt.cninfo.net> /Бугатын тойм/
10. Мөн тэнд
11. “Өдрийн сонин”, 2004.09.20 №233 /1735/., <http://www.bt.nm.cninfo.net> /Бугатын тойм/
12. “Time table Air China”, 2004, Summer-Autumn, pp.27-28
13. “Өвөр Монголын их толь бичиг” /Нэймэнгу да цыдянь/, Хөх хот, 1991, 769, 767, 771, 761, 757, 755, 753 дахь тал., <http://www.bt.nm.cninfo.net> /Бугатын тойм/., <http://www.baotou.gov.cn> /Ли Цзяньчжун. Бугатын эдийн засгийн шинэ тогтолцоог байгуулах талаарх судалгаа, 2002/
14. У Кан-пин. Баруун бүс нутгийн эдийн засгийн өсөлтийн арга зам /Сибу цзинцзи цзэньчжан дэ фанши юй туцзин/, Бээжин, 2004, 315-318 дахь тал.